БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

"ДАЛАНЗАДГАДЫН 50 МВт-ЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ"-ИЙН ЭХ ЗАГВАР (ЭСКИЗ) ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 02 сарын 04-ны өдөр Дугаар 2026/D-05 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	• Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4.6 дахь заалт • Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөр • Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн "Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай" 43 дугаар тогтоол • Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Хөгжлийн төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 122 дугаар тогтоол • Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тэмдэглэл • Өмнөговь аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/947 дугаар захирамж
2.	Байршил	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Үйлдвэрийн бүсийн хойд тал
3.	Обьектын бүрэлдэхүүн, хүчин чадал, ажлын биеийн параметр	**Төслийн хүчин чадал:** Цахилгаан: 2х25 МВт; Усаар түгээх дулаан: 100 Гкал/цаг-аас багагүй. **Зуухны техникийн үзүүлэлт: Эргэлдэх буцлах давхарга бүхий шаталтын технологитой зуух (нэгж тоноглол)** Зуухны тоо: 2 ширхэг Уурын үйлдвэрлэх хамгийн их хэмжээ: 220 т/ц-с багагүй Хурц уурын гарах даралт: 9.8 МПА Хурц уурын гарах температур: 540^{0}С Тэжээлийн усны температур: 215^{0}С **Турбин №1 техникийн үзүүлэлт: ПТ-25-90 маягийн дүйцэхүйц** Турбины хэвийн хүчин чадал: 25 МВт Эргэлтийн хурд: 3000 эрг/мин Орох уурын даралт: 8.83 МПА Орох уурын температур: 535^{0}С Үйлдвэрийн отборын уурын зарцуулалт: 125 т/ц-аас багагүй; Дулаацуулгын отборын уурын зарцуулалт: 53 т/ц-аас багагүй; **Турбин №2 техникийн үзүүлэлт: Т-25-90 маягийн дүйцэхүйц** Турбины хэвийн хүчин чадал: 25 МВт; Эргэлтийн хурд: 3000 эрг/мин; Орох уурын даралт: 8.83 МПА; Орох уурын температур: 535^{0}С; Дулаацуулгын отборын хүчин чадал: 85 т/ц-аас багагүй;

		Агаарын хөргөлттэй конденсаторын техникийн үзүүлэлт: (Нэгж блок тус бүр агаарын хөргөлттэй конденсатортэй, усны зарцуулалт нь турбины техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангахуйц байна. Хүйтний нөхцөлд мөстөлтөөс сэргийлэх, зуны нөхцөлд бороожуулах туслах тоноглолуудтай байна.) **Генераторын техникийн үзүүлэлт:** Нэгж тоноглол Төрөл: 3 фаз, хэвтээ байрлалтай Хүчин чадал: 25 МВт (30 МВА) ; Генераторын гаралтын хүчдэл: 10.5 кВ; Эргэлтийн хурд: 3000 эрг/мин; Давтамж: 50 Гц; Давтамж хэлбэлзэх хүрээ: +3% - -5%; Чадлын итгэлцүүр: 0.85 (lag)- аас багагүй ; Хөргөлтийн систем: ердийн агаарын хөргөлттэй; **Блок трансформаторын техникийн үзүүлэлт (ТР-1,2): Нэгж тоноглол** Ажиллах орчин: -40....+40^{0}С; Хүчин чадал: 63 МВА /цаашид өргөтгөлийн хүчин чадлаар урьдчилан тооцсон/; Фазын тоо: 3 фаз, 3 ороомогтой; Өндөр талын хүчдэл: 115 кВ; Дунд хүчдэл: 35 кВ Нам талын хүчдэл: 10.5 кВ генераторын хүчдэлтэй тохирох; Давтамж: 50 Гц; **Дотоод хэрэгцээний 10.5/6.3 кВ-ын трансформаторын техникийн үзүүлэлт (ДХТ-2,4)** Ажиллах орчин: -40...+40^{0}С; Фазын тоо: 3 фазын, 2 ороомогтой; Хүчин чадал: Тооцоогоор сонгоно; Өндөр талын хүчдэл: Генераторын хүчдэлтэй тохирох; Нам талын хүчдэл: 6.3 кВ; **Дотоод хэрэгцээний 10/0.4 кВ-ын трансформаторын техникийн үзүүлэлт (ДХТ-1,5):** Ажиллах орчин: -40...+40^{0}С; Хэлхээний тоо: 3 фаз, 2 ороомогтой; Хүчин чадал: Тооцоогоор сонгоно; Өндөр талын хүчдэл: 10.5 кВ; Нам талын хүчдэл: 0.4 кВ; Давтамж: 50 Гц; **Бэлтгэл трансформаторын техникийн үзүүлэлт (ДХТ-3):** Ажиллах орчин: -40...+40^{0}С; Фазын тоо: 3 фазын, 2 ороомогтой; Хүчин чадал: Тооцоогоор сонгоно Өндөр талын хүчдэл: 10.5 кВ; Нам талын хүчдэл: 0.4 кВ; Давтамж: 50 Гц; **110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын техникийн үзүүлэлт** Ажиллах орчин: -40...+40^{0}С; Хэлхээний тоо: 2 хэлхээт; Хүчдэл: 110 кВ;

		Тулгуур: Төмөр бетон, Зэврэлтээс хамгаалагдсан металл; Тусгаарлагч: Олон улсын стандартуудыг хангасан Дамжуулагч утас: АС-240/39 дамжуулагчтай дүйцэх.
4.	Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага	**А. ТӨСЛИЙН АЖЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА** Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшил бүхий газарт Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааны эрчим хүч хослон үйлдвэрлэдэг станц шинээр барих. Дээрх ажлын хүрээнд дулааны цахилгаан станцын **эх загвар (эскиз)** зураг төсөл боловсруулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Энэхүү даалгавар нь зураг төсөл, барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах бүх зүйлийг нарийвчлан зааж өгөх зорилгогүй ч гол тоног төхөөрөмжийн нэр, төрөл, хүчин чадал, төслийн хүрээнд хийвэл зохих ажлын ерөнхий ангилал, чанарын хязгаар зэргийг зааж өгнө. Дулааны цахилгаан станцын зураг төсөл төлөвлөлт нь найдвартай ажиллагаа, бэлэн байдал, харилцан нөхөж ажиллах байдал, засвар үйлчилгээ болон эдийн засгийн үр ашгийг тооцсон байна. Ажлын хүрээ нь энэ даалгаврын бүлэг бүрт заасан бүх тоног төхөөрөмж, ажлыг багтаасан дараах ажил үйлчилгээг хамарсан байна. Үүнд: 1. Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, архитектур төлөвлөлтийн даалгавар, холбогдох техникийн нөхцөлүүдийг баримтлан барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах эх загвар (эскиз) зураг боловсруулах; 2. Төсөл хэрэгжүүлэх байршилд хийгдсэн инженер геологи, геодезийн судалгаа, дүгнэлтийг үндэслэн эскиз зураг төслийг боловсруулах; 3. Дулааны цахилгаан станцын эскиз зураг төслийг боловсруулж монгол хэл рүү хөрвүүлэн, Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм, журмын дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудын зөвшөөрлийг авч, экспертээр хянуулан баталгаажуулах; 4. Тоног төхөөрөмжийг хүлээн авах, технологийн дагуу хадгалах түр агуулах байр бэлтгэх; 5. Станцын ус хангамжийн эх үүсвэрийн техник тоног төхөөрөмжийг шинээр төлөвлөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх; 6. Түлш дамжуулах цехийн иж бүрдэл туслах тоноглолуудыг суурилуулж, түлш нөөцлөх талбайг байгаль орчинд ээлттэй байдлаар төлөвлөх; 7. Станцаас гарсан үнсийг хадгалах үнсэн сан барих; 8. Хими, ус цэвэрлэгээний цех нь механик болон орчин үеийн мембрант шүүлтүүрээр иж бүрэн тоноглогдсон байх; 9. ДЦС нь 110/35/10кВ-ын шинэ дэд станцтай байна. Үүнд: 9.1 Шинээр баригдах дэд станц нь хүчдэл тохируулагчтай 63 МВА хүчин чадалтай 2ш хүчний трансформатортай, 2 систем шин бүхий ил хуваарилах байгууламж байна; 9.2 Ил хуваарилах байгууламжид дотоод хэрэгцээний 10.5 кВ–ын бэлтгэл шинийг тэжээх ДХТ-2,4 10.5/6.3кВ-ын

		2ш трансформатор, ДХТ-1,3,5 10.5/0.4 кВ-ын 3ш трансформаторыг суурилуулах (хүчин чадлыг тооцоогоор сонгох); 10. Шинэ дэд станц нь хуучин "110/35/10кВ-ын Даланзадгад дэд станц"-тай хос хэлхээ 110кВ-ын ЦДАШ-аар холбогдоно. Үүнд: 10.1 Шинээр 110 кВ-ын 2 хэлхээ 10 км орчим ЦДАШ барина, дамжуулагчийн төрөл АС-240/39; 10.2 "110/35/10кВ-ын Даланзадгад дэд станц"-ыг 110 кВ-ын хоёр гаргалгаагаар өргөтгөн тоноглох. **Б. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА** 1. Төслийн талбайд хийсэн геологи, геодезийн судалгаанд үндэслэн барилгын суурь, үндсэн багана, тоног төхөөрөмжийн суурь зэргийн хийц материалыг сонгох; 2. Барилгын үндсэн хийц нь ган каркастэй, төмөр бетонон хийцтэй байх; 3. Барилга байгууламжууд нь байгалийн гэрэлтүүлгийг чөлөөтэй нэвтрүүлэхээр хийгдсэн байх; 4. Төслийн талбайд хийсэн геодезийн судалгаанд үндэслэн барилга, байгууламж барих газрын хөрсийг хүчитгэх, хөрсний усны нэвчилтгүй болгох; 5. Бүх барилга, байгууламжууд нь аянга зайлуулах газардуулгын системтэй байх; 6. Барилга, байгууламжуудын металл хэсгүүд нь зэврэлтээс хамгаалагдсан байх; 7. Станцын үндсэн болон бусад барилгууд нь цаг агаарын эрс тэс уур амьсгалыг тооцсон, урт удаан хугацаанд ашиглах боломжтой дулаанжуулалт болон агааржуулалтын системтэй байх; 8. Ашиглалт, засварын ажилчдын ахуйн байр нь инженер техникийн ажилтнуудын оффис, ажилчдын усанд орох хувцас солих өрөө, цайны газартай байх; 9. Станцын үндсэн барилга нь тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ явуулах боломжтой засварын талбайтай байх; 10. Засварчдын ажлын байр болон тоног төхөөрөмжийн сэлбэг материал хадгалах агуулахтай байх; 11. Бүх барилга, байгууламжууд нь нэгдсэн холбоо, дохиоллын системтэй байх; 12. Бүх барилга, байгууламжууд нь галын аюулаас хамгаалах нөхцөлийг хангасан гал унтраах тоноглолоор бүрэн тоноглогдсон байх /галын усны нэгдсэн шугам, галын хор, галын дохиолол гэх мэт/; 13. Барилга тус бүр нь тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний үеийн даацыг тооцсон гүүрэн кран болон өргөх зөөх механизмтай байх; 14. Барилга нь хоёр талын орц, гарцтай байх ба орц гарцуудыг ямагт чөлөөтэй байхаар төлөвлөх; 15. Барилга, байгууламжууд нь аваарын шат, тавцан, гарцтай байх; 16. Барилга, байгууламжууд нь ачаа өргөх, зөөх тусгай зориулалтын даацын цахилгаан шаттай байх; 17. Барилга, байгууламжийн гадаад, дотоод өнгө, будаг, тоног төхөөрөмжийн өнгө, будаг нь үйлдвэрийн гоо зүй болон таних, ялгах нөхцөл шаардлагыг хангасан байх;

18. Станцын орчны тохижилтыг иж бүрэн төлөвлөж, барилга байгууламжуудын хоорондох зорчих хэсгийн зам, талбай, авто машины зогсоол, гэрэлтүүлэг, орц, гарц, ногоон байгууламжийг хийсэн байх;
19. Үйлдвэрийн зам, талбайд тогтсон борооны усыг төвлөрсөн санд хуримтлуулж дахин ашиглах системтэй байх;

В.ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Тоног төхөөрөмж, барилга, байгууламжийн байрлалын ерөнхий төлөвлөлтийг хийхдээ цаашид өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлэх боломжтойгоор зай талбайг оновчтой зохион байгуулах;
2. Станц нь DCS системүүдийг нэгтгэсэн хяналт удирдлагын системтэй байх. Хяналт удирдлагын систем нь ерөнхий цахилгаан ачааллаас хамааран зуух, турбины ачааллыг автоматаар тохируулдаг байх. Уг системийг цахилгаан, дулааны удирдах щитнээс хянаж удирдах боломжтой байх;
3. Станцын үндсэн тоноглолуудын аваарын бичлэгийн төхөөрөмжтэй байх;
4. Үнсийг барилга болон бусад материал ашиглах зорилгоор үнс хадгалах савыг ашиглагч байгууллагатай зөвшилцөж шийдэх;
5. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ өндөртэй утаа сорогч, үлээх салхилуур, тэжээлийн усны насосууд нь давтамж хувиргагчтай байх;
6. Үйлдвэрийн хаягдал усыг эргүүлэн ашиглах системтэй байх;
7. Шинэ станцын ариутгах татуургын шугамыг хотын төв ариутгах татуургын шугамтай холбох;
8. Газар дээрх байрлах инженерийн шугам сүлжээ нь хөлдөлтөөс сэргийлсэн дулаалгатай байх ба машин механизм болон тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэхээр төлөвлөх;
9. Газар доор байрлах инженерийн шугам сүлжээ нь хөлдөлтөөс сэргийлсэн дулаалгатай байх ба бетон худаг, сувагчлалтай байх;

Г. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Түлш дамжуулах хэсгийн техникийн шаардлага:

Тоног төхөөрөмжийн сонголт нь ажиллагааны ямар ч горимд станцыг нүүрсээр тасралтгүй хангах боломжтой байх ба схемийн хувьд оновчтой зохион байгуулалттай байна.

1. Түлш дамжуулах хэсгийн тоноглолын хүчин чадлыг 50 МВт-ын дулааны цахилгаан станцын шаардлагыг хангаж байхаар тооцох. Түлш дамжуулах хэсгийн ерөнхий төлөвлөлтийг хийхдээ захиалагч талын мэргэжилтнүүдтэй зөвшилцөх;
2. 50 МВт-ын станцад зориулсан нүүрс хадгалах талбайг битүү байдлаар, станц өвлийн оргил ачааллын үед хэвийн ажиллах хэмжээний нөөцтэй байхаар төлөвлөх;
3. Туузан тээвэгчүүд болон бутлагчууд нь давтамж хувиргагчтай хөдөлгүүр, редукторoор тоноглогдсон байх;

		4. Түлш дамжуулах хэсгийн тоноглолууд нь нэг нэгнээсээ хамаарсан удирдлагын болон хамгаалалтын цогц системтэй байх; **Зуухны тоноглолд тавих техникийн шаардлага:** Зуух нь уур-усны ердийн эргэлттэй, нам температурын буцалмал давхаргын /CFB/ шаталтын технологитой, үнсийг хуурай байдлаар зайлуулах систем болон утааны хийн хорт агууламжуудыг ялган саармагжуулах системээр иж бүрэн тоноглогдсон, турбины цахилгаан ачааллаас хамааран ачааллаа автоматаар тохируулдаг бүрэн автомат хяналт удирдлагын системтэй байна. Үүнд: 1. Зуухны технологи ажиллагаа нь автомат тохируулгатай, DCS, DEH хяналт-удирдлагын системтэй байх. 2. Зуухны дотор хананд үүсэх тортог, шлак зайлуулах үлээлгийн системтэй байх. Мөн уур халаагч дээр тогтсон үнс, шлак зайлуулах үлээлгийн системтэй байх; 3. Утааны хийн агууламжийг хянах мониторингийн системтэй байх; 4. Үнсийг тээвэрлэх, хадгалах системийн техник технологи, тоног төхөөрөмжийг иж бүрнээр нь шийдвэрлэх; 5. Зуухны шугам, хоолой, халах гадаргуу нь олон улсын ASME, EN стандарттай дүйцэхүйц стандартын шаардлага хангасан гангаар хийсэн байх; **Турбогенераторын тоноглолын техникийн шаардлага:** Шинээр суурилуулах уурын турбогенератор нь хэвийн горимд ажиллах үедээ захиалагч талаас тавьж байгаа цахилгаан болон дулааны эрчим хүчний ачааллыг бүрэн авч ажиллах хүчин чадалтай байх бөгөөд хэрэглээнээс хамааран цахилгаан, дулааны ачааллыг автоматаар тохируулдаг бүрэн автомат хяналт удирдлагын системтэй байна. 1. Турбины технологи ажиллагаа нь автомат тохируулгатай, DCS, DEH хяналт-удирдлагын системтэй байх. Энэ систем нь станцын цахилгаан ачааллаас хамааран турбины цахилгаан ачааллыг автоматаар тохируулдаг байх; 2. Турбины уур, ус, конденсатын шугам хоолой нь олон улсын стандартын шаардлага хангасан гангаар хийсэн байх; 3. Турбины уур, усны шугам хоолой, тохируулах регулятор, конденсат насос, хаалт, арматур зэрэг туслах тоног төхөөрөмж нь турбин зуны цэвэр конденционны болон өвлийн дулаацуулгын аль ч горимд ажиллахад хүчин чадлын хувьд бүрэн хүрэлцэхүйц, хэвийн ажиллаж байхаар сонгосон байх; 4. Турбины конденсаторын хөргөлтийн гадаргууг конденционны болон дулаанжуулалтын горимд хэвийн ажиллах боломжтой байхаар тооцон сонгох;
5.	Зураг төсөл боловсруулах үе шат	- Дэвсгэр зургийн тодруулга хийх; - Төлөвлөлтийн дэд бүтэц, инженерийн байгууламжийн трассыг ашиглагч байгууллагаас тодруулга авах; - Инженер геологийн дүгнэлт ; - Станцын барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах эх загвар зураг боловсруулах;

		- Станцын барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах эх загвар зургийг ашиглагч байгууллагуудтай зөвшилцөх; - Эх загвар зураг төслийг экспертизээр баталгаажуулах;
6.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	Монгол Улсын хуулиуд: - Барилгын тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль; - Усны тухай тууль; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; - Агаарын тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд. Норм, норматив стандарт: - Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм; - Эрчим хүчний нэгдсэн сүлжээний дүрэм; - Олон улсын ASME, EN, IEC, IEEE, MNS; - Дулааны сүлжээ БНбД 41-05-18; - Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам; - Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам; - Барилгын ажилд зураг зохиогчийн хяналт тавих дүрэм; - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09; - Барилгын дулаан хамгаалалт БНбД 25-01-20; - Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНбД 41-04-13; - Бусад холбогдох дүрэм, журам, стандартууд, төсөв зохиох аргачлалууд;
7.	Галын аюулгүй байдлын нөхцөл	7.1 Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21-01-02 7.2 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгуйн норм дүрэм.
8.	Зураг төсөл зохиоход тавигдах шаардлага	Техникийн нөхцөл, энэхүү зургийн даалгаврын дагуу эх загвар зураг төслийг боловсруулж ашиглагч, захиалагч байгууллагатай зөвшилцөж сонголт хийнэ. Зураг төсөлд эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар ажлын зураг төсөл, төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргууулах.
9.	Шугам сүлжээний трасс сонголтод тавигдах шаардлага	Бэлтгэл арга хэмжээ: - Шинээр төлөвлөж буй шугамыг тухайн орчинд төлөвлөгдсөн бусад инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөлтэй уялдуулах; - Инженер геологи, гидрогеологи, гидрологийн тооцоо судалгаа хийх, хөрсний усны түвшин доошлуулах шүүрүүлэх байгууламж хийж шугам сүлжээг хөрсний уснаас хамгаалах арга хэмжээ авах. Авто зам: - Төлөвлөж байгаа барилга байгууламж, авто замын трасстай уялдуулах.

10.	Зураг төсөл боловсруулах байгууллага	Эрчим хүчний яамнаас олгодог зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх бүхий хуулийн этгээд байна.
11.	Захиалагч байгууллага	Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын газар
12.	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээний заасан хугацаанд
13.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг үндэслэн зураг төсөл боловсруулах.
14.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд - трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Станцын барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай, орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх; - Шугам сүлжээний трасс сонголтыг бусад инженерийн шугам сүлжээтэй холбогдох нормын дагуу газар чөлөөлөлт хамгийн бага байх хувилбарыг сонгон холбогдох байгууллагуудтай зөвшилцөх; - Шинээр барих үнсэн сан, гүний худаг, цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг төлөвлөхдөө аймгийн холбогдох төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөх; - Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулах; - Эх загвар зураг төсөлд авто зам, явган зам, гүүр, ногоон байгууламж, гэрэлтүүлгийг холбогдох дүрэм, журмын дагуу тооцож тусгах; - Барилга угсралтын үеийн түр шугам татах боломжтой эсэхийг мэргэжлийн байгууллагатай хамтран газар дээр нь үзлэг хийж шийдвэрлэх.
15.	Хавсралт материал	Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын ТЭЗҮ

ХЯНАСАН:
Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын
Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин

БОЛОВСРУУЛСАН:
Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын
Стратеги төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Пунцагбалжир

---oOo---